



“ҮЙЛДВЭРЛЭГЧ-ХОВД” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Үйлдвэрлэлийг дэмжих тухай” хууль, “Жижиг дунд үйлдвэрийн тухай” хууль, Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр, Ховд аймгийн хөгжлийн стратегийн 2015-2025 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 оныг “Өрхийн болон жижиг дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдийг дэмжих жил” болгон зарласан зэрэг баримт бичгүүдэд үндэслэн “Ажлын байр нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих жил”-ийн хүрээнд өрхийн үйлдвэрлэгчдийг дэмжин ажлын байр бий болгох зорилгоор “Үйлдвэрлэгч Ховд” хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх хөнгөлөлттэй зээл /цаашид “Зээл” гэх/-ийн төсөл сонгон шалгаруулахтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Зээл авахаар үйлдвэр эрхлэгчээс ирүүлсэн төслийг сонгон шалгаруулж шийдвэр гаргах чиг үүрэг бүхий “Төсөл сонгон шалгаруулах хороо” /цаашид “Хороо” гэх/ төслийг хүлээн авч төсөл сонгон шалгаруулах хорооны хуралд оруулах, шийдвэр гаргах чиг үүрэг бүхий хороо ажиллана.

1.3. Зээл эргэн төлөгдөх хугацаатай хяналтын зардалтай байна.

Хоёр. Хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр, нөхцөл

2.1 Зээлийн эх үүсвэр нь дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

2.1.1 Улс аймгийн төсвийн хөрөнгө

2.1.2 Орон нутгийн хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардал

2.1.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө

2.1.4 Олон улсын болон хандивлагч орнуудын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

2.1.5 Олон улсын банк санхүүгийн байгууллага

2.1.6 Бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

2.1.7.Эх үүсвэрийг журамд зааснаас бусад зориулалтаар ашиглахыг хориглоно.

Гурав. Төслийн цар хүрээ

3.1.Төсөлд оролцогчид дараах чиглэлийн үйлдвэрлэгчид байна.

-Жижиг дунд үйлдвэр эрхлэгчид

-Өрхийн үйлдвэрлэгчид

-Ахуйн үйлчилгээ эрхлэгч

3.2.Тухайн жилд аймаг орон нутгаас олгосон санхүүжилтийн 50-аас доошгүй хувь нь жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихэд зориулагдсан байна.

3.3.Зээлийг жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэн өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг үйл ажиллагаагаа өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, түүхий эд материалаа татах, ажлын байраа нэмэгдүүлэхэд зориулан олгоно.

Дөрөв. Төсөл шалгаруулах хорооны чиг үүрэг

4.1.Хороо нь хорооны дарга буюу аймгийн орлогч дарга, нарийн бичгийн дарга-салбар хариуцсан мэргэжилтнээс бүрдсэн 7 хүний бүрэлдэхүүнтэй байна.

4.2.Хороонд төрийн бус байгууллагын 3 төлөөлөл оролцоно.

4.3.Хороо хуралдааны зарчмаар шийдвэрээ гаргах ба хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд нь төсөл сонгон шалгаруулах хуралд саналын тус бүр нэг эрхтэйгээр оролцоно.

4.4.Хорооны гишүүдийн олонх ирснээр хурал хүчинтэйд тооцогдох ба тэмдэглэл хөтөлж, олонхын саналаар шийдвэр гаргана.

4.5.Хурлын тэмдэглэлд хуралд оролцсон бүх гишүүд, хурлын шийдвэрт хорооны дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

4.6.Хороо дараах эрхтэй байна.

4.6.1.Төсөл хүлээн авах эцсийн хугацаа, байршил, хаяг, холбоо барих утасны дугаар гэх мэт зүйлсийг тусгасан зар мэдээллийг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх хугацааг тогтоох

4.6.2.Зээл хүссэн төслийг сонгон шалгаруулах хурлын товыг батлах

4.6.3.Төслийг хуралдаанаар хэлэлцэж, шийдвэрлэх

4.7.Хороо нь дараах үүрэгтэй байна.

4.7.1. Хорооны гишүүн нь ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж хувийн ашиг сонирхолд нөлөөлөхүйц шийдвэр гаргах тохиолдолд хуралд оролцохоос татгалзаж, татгалзах хүсэлтээ бичгээр хорооны даргад гаргах

4.7.2. Хорооны гишүүд хурлын шийдвэр, зөвлөлдсөн асуудлыг бусдад мэдээлэхгүй байх, үнэн зөв шалгаруулах, бусдад давуу байдал бий болгохоос сэргийлэх

4.7.3. Хорооны гишүүд холбогдох хууль, журам зөрчихгүй байх

4.7.4. Төсөл сонгон шалгаруулах хорооны дарга, гишүүд нь төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай газар дээр нь үзэж танилцаж баталгаажуулсан байх

4.7.5. Хороо нь зээлийн хэрэгжилтэд хяналт тавина.

Тав. Төсөлд тавигдах шаардлага

5.1. Зээл хүсэгчийн ирүүлэх төсөл нь үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт болон хүний нөөцийн удирдлагын тухай мэдээлэл зах зээлийн судалгаа, эдийн засгийн тооцоо, дүгнэлт, хавсралт гэсэн хэсгээс бүрдсэн байна.

5.2. Төсөл хэрэгжүүлэгч нь ижил төстэй хөтөлбөрт хамрагдаж зээл аваагүй байна.

5.3. Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн үйл ажиллагааг 3-аас доошгүй жил эрхэлсэн, тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүн зах зээлд гаргаж, хэрэглэгчдэд танигдсан байна.

5.4. Төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэлд дараах зүйлсийг тусгана.

5.4.1 Төслийн товч агуулга

5.4.2 Иргэн хуулийн этгээдийн нэр

5.4.3 Үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй хаяг байршил, иргэн, хуулийн этгээдийн албан ёсны хаяг төсөл хэрэгжих байршил

5.4.4 Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ, түүнээс өөрийн оруулах хөрөнгийн хэмжээ

5.4.5 Үйлчилгээ, үйлдвэрлэл болон худалдах бүтээгдэхүүний нэр төрөл

5.4.6 Жилийн эргэлт, борлуулалт, экспортод эзлэх хувь

5.4.7 Одоогийн эрхэлж байгаа бизнесийн талаарх мэдээлэл

5.5. Үйлдвэрлэл, үйлчилгээ үйл ажиллагааны талаарх мэдээлэлд дараах зүйлийг тусгана.

5.5.1 Үйлдвэрлэл, үйлчилгээний технологийн ажиллагаа

- 5.5.2 Түүхий эдийн чанарын үзүүлэлт
- 5.5.3 Түүхий эдийн нөөц
- 5.5.4 Үйлдвэрлэлийн хүчин чадал
- 5.6. Удирдлага зохион байгуулалт болон хүний нөөцийн удирдлагын талаарх мэдээлэлд дараах зүйлийг тусгана.
 - 5.6.1 Удирдлагын бүтэц орон тоо
 - 5.6.2 Ажиллагсдын мэргэжил, мэргэшлийн ур чадвар
 - 5.6.3 Шинээр бий болгох ажлын байрны тоо
- 5.7. Зах зээлийн судалгаанд дараах мэдээллийг тусгана.
 - 5.7.1 Зах зээлийн төлөв байдал /SWOT шинжилгээ/
 - 5.7.2 Хэрэглэгчдийн тодорхойлолт
- 5.8. Эдийн засгийн тооцоонд дараах мэдээллийг тусгана.
 - 5.8.1 Үндсэн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний нийт орлого
 - 5.8.2 Борлуулалтын орлогын тооцоо
 - 5.8.3 Үйлдвэрлэлийн зардлын тооцоо
 - 5.8.4 Төлөвлөж байгаа борлуулалтын төлөвлөгөө
 - 5.8.5 Үйлдвэр, үйлчилгээ, худалдааны үр ашгийн тооцоо
 - 5.8.6 Төслийн өгөөж өртгийн тооцоо
 - 5.8.7 Төслийн эрсдэлийн удирдлагын тооцоо, даатгалд хамрагдах тооцоо
 - 5.8.8 Байгаль орчинд ээлтэй болон хор хөнөөлгүй, үйлдвэрлэл явуулах тооцоо
- 5.9. Төсөлд дараах материалыг хавсаргана.
 - 5.9.1 Иргэний үнэмлэхийн хуулбар
 - 5.9.2 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ
 - 5.9.3 Тоног төхөөрөмжийн жагсаалт, зураг
 - 5.9.4 Зээлийн эргэн төлөлтийн хуваарь
 - 5.9.5 Үйлдвэрлэх болон худалдах бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл зураг
 - 5.9.6 Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан
 - 5.9.7 “Жижиг дунд үйлдвэрийн тухай” хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгүүлсэн тухай тодорхойлолт /ХХААГазраас/
 - 5.9.8 Нийгмийн даатгалын хугацаа хэтэрсэн өртэй эсэх талаарх тодорхойлолт

5.9.9 Зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл /монгол банкны мэдээлэл/

5.9.10 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын өртэй эсэх тодорхойлолт

5.9.11 Харилцдаг татварын байгууллагын хугацаа хэтэрсэн өртэй эсэх талаарх тодорхойлолт

Зургаа.Төсөл сонгон шалгаруулалт

6.1.“Төсөл сонгон шалгаруулах хороо”-г аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж ажиллуулна.

6.2.Аймгийн ЗДТГ- ын ХОХБТХ-ийн тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн зээл хүсэгчээс ирүүлсэн төслийг хүлээн авч төслийн бүрдлийг нягтлан шаардлага хангасан төслийг хорооны хуралд танилцуулна.

6.3. Шалгаруулах хороо нь зээл хүссэн иргэн аж ахуйн нэгжийн хэрэгцээ, шаардлагаас хамааруулан хуралдааныг сард 2-оос доошгүй удаа зохион байгуулна.

6.4.Шалгаруулах хороо зээл хүссэн хуулийн этгээдийн төсөл, саналыг үндэслэн үнэлгээ хийж, хуралдаанаар олонхын саналаар шалгарсан төсөлд зээл олгох шийдвэрийг гаргана.

6.5.Төсөл сонгон шалгаруулахдаа төсөл ирүүлэгчийг оролцуулан төслийг хамгаалуулан дэмжих эсэхийг шийдвэрлэнэ.

6.6.Шалгаруулах хороо нь төсөл шалгарсан тухай хуралдааны шийдвэрийг тухайн зээл хүсэгчийн материалын хамт төрийн санд уламжилна.

6.7.Хорооны хурлын шийдвэр гарснаас хойш хорооны нарийн бичгийн дарга ажлын 3 хоногт багтаан төсөл ирүүлсэн иргэн, хуулийн этгээдэд хариу өгнө.

6.8.Төсөл сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг “Шилэн дансны тухай” хуулийн 3.2.3-д заасны дагуу нийтэд ил тод мэдээлнэ.

6.9.Хороо нь төсөл хүлээн авах хугацаа зарлагдахаас бусад үед төсөл хүлээн авахгүй.

Долоо. Төслийн санхүүжилт

7.1.Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах нийт төсөвт өртгийн 30 хүртэл хувийг тухайн төсөл хэрэгжүүлэгч гаргаж, үлдэх хувийг “Үйлдвэрлэгч Ховд” хөтөлбөрийн эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

7.2.Төсөлд оролцогчдын чадвар, цар хүрээ жижиг дунд үйлдвэр, өрхийн үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэлийн технологийн онцлогтой уялдуулан дараах нөхцөлөөр зээл олгоно.

- Зээлийн хэмжээ 150 сая төгрөг хүртэл
- Хугацаа 3 жил хүртэл
- Зээлийн хүү сарын 0.25 хувь

7.3 Төсөлд барьцаа тавина. Төсөл хэрэгжүүлэгч өөрийн оролцооны хөрөнгө болон зээлийн санхүүжилтээр авсан тоног төхөөрөмжийг барьцаа болгон ашиглаж болно. Үүнийг зээлийн болон барьцаа хөрөнгийн гэрээгээр зохицуулна.

7.4 Төсөлд батлагдсан мөнгийг төсөл хэрэгжүүлэх үе шатаар нь хянаж санхүүжүүлнэ.

7.5 Эхний жилд зээлийг төлөх хуваарийг харилцан тохиролцож хөнгөлөлт эдлэх боломжийг гэрээнд тусгаж болно. Дараагийн 2 жилд зээлийг хуваарийн дагуу төлнө. Үүргээ биелүүлээгүйн улмаас гарах алдангийн хэмжээг зээлийн гэрээгээр зохицуулна.

Найм. Хариуцлага

8.1.Зээлдэгч нь олгосон зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон бол зээлдэгчийн эх үүсвэрийг буцаан татаж, холбогдох байгууллагад шилжүүлнэ.

8.2.Төсөл сонгон шалгаруулах хорооны гишүүн нь уг журмын 4.7.1, 4.7.2, 4.7.3, 4.7.4 дахь заалтуудыг зөрчсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд хорооны гишүүнээс хасах буюу холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.